

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүчингүй болгож буй эрх зүйн актууд



Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний ахлах менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Энхжаргалын Азаяа

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
azzaya.enkhjargal@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn



Хураангуй

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасны дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглодог. Тус зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор өнөөдрийг хүртэл хүчингүй болгосон захиргааны хэм хэмжээний актуудыг дор танилцуулсан болно.



Үндэслэл

2025 оны 2-р сарын 06-ны Зөвшөөрлийн зөвлөлийн 01 тоот дүгнэлт

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Зөвшөөрлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулж 01 тоот дүгнэлтийг баталсан байна. Тус дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцаа зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасахыг даалгажээ.

Үүнтэй холбоотойгоор холбогдох эрх бүхий байгууллагууд өөрсдийн баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцаа зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох арга хэмжээг авч эхэлсэн байна.

ХҮЧИНГҮЙ БОЛСОН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТУУДЫН ЖАГСААЛТ

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх бүхий байгууллагуудын хүчингүй болгосон хэм хэмжээний актуудын жагсаавал:

I. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.10 Дугаар 35	2021.06.25-ны өдрийн 147 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам” 2021.11.18-ны өдрийн 245 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох, түүнд хяналт тавих журам”

II. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.17 Дугаар A/64	2019 оны A/156 дугаар тушаалаар батлагдсан “Газар өмчлөх тухай хүсэлтийн загвар, Газар эзэмших тухай хүсэлтийн загвар, Газар ашиглах тухай хүсэлтийн загвар, Хүсэлт хүлээн авсан тухай тодорхойлолтын загвар, Хариу өгөх мэдэгдлийн загвар, Газар өмчлөгчийн улсын бүртгэлийн маягтын загвар, Газар өмчлөх, эзэмших, ашиглах тухай хүсэлт бүртгэх маягтын загвар, Газар эзэмших эрх шилжүүлж авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдлийн загвар”
2025.02.17 Дугаар A/65	2021 оны A/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

ХҮЧИНГҮЙ БОЛСОН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТУУДЫН ЖАГСААЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

III. Харилцаа холбооны зохицуулах хороо:



Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.13 Дугаар 32	"Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлал" батлах тухай 2021 оны 75 дугаар тогтоол
2025.02.13 Дугаар 34	"Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам"-ыг батлах тухай 2021 оны 73 дугаар тогтоол
2025.02.13 Дугаар 35	"Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай" 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 105 тоот тогтоол
2025.02.13 Дугаар 38	"Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журам шинэчлэн батлах тухай" 2020 оны 65 тоот "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 64 тоот тогтоол



IV. Эрчим хүчний хороо:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.20 Дугаар 41	2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 725 дугаар тогтоолоор батлагдсан "Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм"

V. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.14 Дугаар A/50	2022 оны A/195 дугаар тушаалаар батлагдсан "Таримал ургамлын үр үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт"

VI. МУ-ын Засгийн газар:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.19 Дугаар 99	2006.06.14-ний өдрийн 137 дугаар тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам"

VII. Цахим хөгжил, инновац, харилцаа холбоо:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.11 Дугаар A/35	2022.11.21-ний өдрийн A/81 дүгээр тушаалаар батлагдсан "Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага"

VIII. Эрүүл мэндийн яам:

Шийдвэр	Хүчингүй болсон хэм хэмжээний акт
2025.02.10 Дугаар A/40	Хүчингүй болгосон Эрүүл мэндийн сайдын 7 тушаалыг эндээс үзнэ үү.

Бизнес эрхлэгчдийн анхааралд

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрх бүхий байгууллагууд өөрсдийн баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж, Зөвшөөрлийн тухай хуулийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд хүчингүйд тооцох ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд өнөөдрийг хүртэл хүчингүй болсон актуудыг жагсаалт болгон танилцууллаа. Энэхүү жагсаалт нь цаашид нэмэгдэж болохыг анхаарна уу.

Иймд, бизнес эрхлэгч та бүхэн хүчингүй болсон актуудыг анхааралдаа авч, үйл ажиллагаагаа явуулахдаа хүчинтэй эрх зүйн актуудыг удирдлага болгоно уу.



Бидэнтэй холбогдоорой!

Та хууль тогтоомжийн нийцлийг хангахтай холбоотой хууль зүйн зөвлөгөө авахыг хүсвэл бидэнтэй холбогдоно уу.

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.